



2013 оны 12 сарын 6-наас 9-ны өдрүүдэд аймгийн Засаг дарга Д.Цэвээнравдангаар ахлуулсан ажлын хэсэг БНХАУ-ын ШУОЗО-ы Алтай аймагт хил боомтын асуудлаар уулзалт хийв. Уулзалтанд оролцох толоологчдийн бүрэлдэхүүнд баруун бүсийн зовлолийн нарийн бичгийн дарга Ц.Нарантуяа, Засаг даргын зовлох А.Хүдрээ, гадаад харилцааны мэргэжилтэн Д.Нямаа, Үенч сумын Засаг дарга Э.Уртнасан, Булган боомтын гаалийн орлогч дарга Н.Лха-Очир, хилийн шалган нэвтрүүлэх албаны дарга Б.Одсүрэн, хилийн толоологчийн орлогч нарын хил гаалийн толоолол, мон Баян-Олгий аймгийн ИТХ-ын дарга Б.Лазатханаар ахлуулсан бүрэлдэхүүн багтав. Энэ удаагийн уулзалтын зорилго нь Булган, Такейшкен боомтонд учирч байгаа хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэх зорилготой байсан бөгөөд уулзалт хэлэлцээр үр дүнтэй боллоо.

Олон улсын статустай, байнгын вйл ажиллагаатай Булган боомтоор зөвхөн энэ онд 143 мянган зорчигч, 12615 мянган тээврийн хэрэгсэл улсын хилээр нэвтэрчээ.

Мон худалдаа, ачаа тээвэр, аялал жуулчлалаас гадна Хошоотийн уурхайгаас нүүрс экспортлох ажил онгорсон 2012 оны 1 сараас 8 сарын хугацаанд туршилтын журмаар эхэлж, 2854 тээврийн хэрэгсэл 183908,08 тонн нүүрс экспортолсон байна. Ийн ходолгоон ихтэй 2 улсын хил гааль, боомтонд олон хвндрэл учирдаг талаар аймгийн Засаг даргад зорчигч, тээвэрчид удаа дараа хвсэлт тавьж байсан. Тухайлбал БНХАУ-ын талд татвар хураамж ондор, хаанаас ямар татвар авч байгаа талаар баримт огдогвй, одорт цайны цагааг урт хугацаанд завсарлаж хвндрэл ввсгэдэг, дарамт шахалт хвнд суртал их зэргийн санал швумжлэлийг олон жилийн туршид зовхон Ховд тодийгвй баруун бvсийн иргэд тэвчсээр ирсэн. Энэ асуудлыг аймгийн Засаг дарга онгорсон 8 сард Үрвмч хотод болсон вээсгэлэн худалдаанд оролцох вээр Шинжааны Засгийн ордонд албан ёсоор шийдвэрлэх талаар санал тавьсан бoгоод энэ саналыг хариу болох уулзалт хэлэлцээр ШУОЗО-ы Алтай аймагт амжилттай боллоо



БНХАУ-ын талаас ШУОЗО-ы гадаад харилцааны газрын намын дарга Вуу Шян, хил хамаарах газрын даргын орлогч Жан Жахуу, Алтай аймгийн намын дарга Дэн Жан уу, намын даргын орлогч, аймгийн Засаг дарга Талгат Усвн болон Такейшкен боомтыг хамаарах дарга, байцаагч, хилийн толоологч нар оролцов.

Булган шалган нэвтрвүлэх боомтоор тээврийн хэрэгсэл нэвтрэн Такейшкен худалдааны цэгт очиход суудлын автомашинаас бүртгэлийн карт, хонох хашааны түрээс, чанарын монго, тээврийн газар зэргийн 500 гаруй юанийн талбар хураамж авдаг байсан. Ачааны автомашинаас 700-1000 орчим юанийн татвар хураамж авдаг бoгоод нотлох баримт болох хураамжийн ямар нэгэн тасалбар огдогвй байсан. Эл асуудлууд шийдвэрлэгдэж 1 тонн ачаанаас 28700 тогрогийн татвар авдаг болжээ. Мон даац хэтрвүлсэн нэрийдлээр

300 юаниар торгодог байсныг больсон байна.

2 талын уулзалтын эхэнд Ховд аймгийн Засаг дарга, баруун бүсийн зовлолийн дарга Д.Цэвээнравдан татвар хураамж буурч, эхнээсээ ажил хэрэг болж байгааг онцлоод дахин хил боомттой холбоотой хэд хэдэн саналыг БНХАУ-ын талд тавьсан юм.



Тухайлбал ажлын цагийн нягтралыг сайжруулах, одорт 3 цаг биш, нэг цаг цайндаа явдаг болох, МоЭнКо компанийн хүсэлтийн дагуу Булган Такейшкен боомтоор нүүрс тээвэрлэх тусгай гарцын тоог нэмэгдүүлэх, бичиг баримтын бүрдүүлэлтийг шуурхай хийж орсон машин тухайн одортоо буцаж гарах нохцлийг хангах, татвар хураамжийн мэдээллийг монгол хэл дээр хорвүүлж байршуулах, зорчигчид хилээр явган гарч, ачаа тээшээ оорсдоо зоодгийг зогсоох зэргийн олон чухал тулгамдаж байгаа асуудлыг хондсон юм. Эдгээр саналыг БНХАУ-ын ШУОЗО-ы тал нааштайгаар хүлээн авч шат дараатай шийдвэрлэхээ албан ёсоор уулзалтын үеэр Вуу Шан дарга мэдэгдлээ. Татвар хураамжийн хувьд БНХАУ-д мордогддог хууль тогтоомжид заасан толбороос бусад торгууль, толборийг авахгүй байхаас гадна энэ мэдээллийг нийтэд ил тод байршуулахаар болсон юм. Мөн одорт 3 цаг завсарладаг байсныг 2014 оны 5 сарын 1-нээс эхлэж больж одорт 1 цагийн завсарлага авч байхаар тохиролцоонд хүрэв. Цаашдаа 2 улсын хил гааль, боомтонд тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээлийг тухай бүрт шийдвэрлэж байх үүднээс уулзалтын байртай болох саналыг БНХАУ-ын ШУОЗО-ы

гадаад харилцааны намын дарга Вуу Шан санал болгосон юм.



Ийнхvv байнгын вйл ажиллагаатай Булган Такейшкен боомтуудад тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх уулзалт vр дvнтэй болж онгорлоо. Цаашдаа Азийн босоо тэнхлэгийн авто зам ашиглалтанд орсноор Орос, Хятад 2 хоршийг холбох гол зангилаа Ховд аймаг болох учраас 2 боомтыг хамгийн хурдан шуурхай вйл ажиллагаатай, найрсаг харилцаатай жишиг болохуйц боомт болгон хогжvvlэхэд аль аль талдаа анхаарч ажиллахаар болсон юм. Энэ нь баруун бvсийн нийт иргэдийн тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд тvлхэц болсон эхний алхам болж чадлаа. Мон Баян-Олгий, Ховд аймаг нь ШУОЗО болон Алтай аймагтай боловсрол, соёл, спорт, эрvvl мэндийн зэрэг олон чиглэлээр хамтарч ажиллах талаар гэрээ санамж бичиг байгуулж, омнох гэрээ, хэлэлцээрийн vр дvнг тооцож ажиллахаар шийдэлд хvрснээрээ энэ удаагийн уулзалт нохорсог, vр дvнтэй боллоо.

**Г.Одонтуяа ЗДТГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан**

